



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

БАТЛАВ.
САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ

/Албан тушаал/



Б.УУГАНБАЯР

/Гарын үсгийн тайлал/

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УДИРДАМЖ**

2023 оны 05 дугаар сарын 11

Дугаар 12/02

Улаанбаатар хот

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ТУХАЙ

Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 6.1, 6.2 дахь заалтууд болон 2023 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Стандарт, хэмжил зүйн салбарын хяналт шалгалтын 2023 оны төлөвлөгөө”-г тус тус үндэслэн улсын хэмжээнд шинээр баригдаж байгаа орон сууцны барилгад суурилуулж буй ус, дулаан, цахилгааны тоолуурын хэмжлийн нэгдмэл байдалд Хэмжил зүйн тухай хууль, түүнтэй нийцүүлэн баталсан дүрэм, журам, холбогдох стандартын хүрээнд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэхэд хяналт шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр:

Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн Газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам” болон бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

Улсын /ахлах/ байцаагч нь нийслэл, аймагт шинээр баригдаж байгаа орон сууцны барилгад суурилуулж буй ус, дулаан, цахилгааны тоолуур, хэмжих хэрэгслүүдийн загварын туршилт, суурилуулалт, баталгаажуулалтын байдалд үзлэг шалгалт хийх, баримт бичгийн бүрдлийг нягтлан шалгах, тайлбар мэдээлэл авах, шаардлагатай тохиолдолд суурилуулж буй тоолуур, хэмжих хэрэгслийг магадлан

13109004

тогтоох шалгалт баталгаажуулалтад хамруулах, илэрсэн зөрчлийг дүрс бичлэг, фото зургаар баримтжуулах зэрэг арга хэлбэрээр хяналт шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн объектын нэр:

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад нийслэл, 21 аймгийн нутаг дэвсгэрт орон сууцны барилга угсралтын ажил гүйцэтгэж буй аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулна.

Шалгалтыг дараах чиглэлээр хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Цахилгаан эрчим хүч, дулаан, цэвэр усаар хангагч байгууллагаас олгосон техникийн нөхцөлтэй эсэх;
2. Техникийн нөхцөлд тухайн барилга байгууламжид суурилуулах ус, дулаан, цахилгааны тоолуурт тавигдах шаардлагыг тусгасан эсэх;
3. Техникийн нөхцөлд заасан тоолуур, хэмжих хэрэгслийг барилгын зураг төсөлд бүрэн тусгасан эсэх;
4. Барилгын зураг төсөлд тусгасан тоолуур, хэмжих хэрэгслийг барилгын цахилгаан, дулаан, цэвэр усны шугам сүлжээнд холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн суурилуулсан эсэх;
5. Тоолуурыг хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэлтэй мэргэжлийн байгууллагаар суурилуулсан эсэх;
6. Суурилуулсан тоолуур, хэмжих хэрэгсэл нь загварын болон улсын баталгааны гэрчилгээтэй, баталгааны хугацаа хүчинтэй эсэхийг тус шалгаж тогтооно.

Тухайн барилгад суурилуулж буй тоолуур, хэмжих хэрэгслийн загварын баталгаа, суурилуулалт, баталгаажуулалт нь хэмжил зүйн хууль тогтоомж, дүрэм журам, холбогдох стандартын шаардлага хангаагүй тохиолдолд хуулийн дагуу шаардлага тавьж, улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, зөрчлийг таслан зогсооно.

Дөрөв. Шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч

Шалгалтыг Стандарт, хэмжил зүйн газрын болон 21 аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хэмжил зүйн хяналтын улсын байцаагчид хийж гүйцэтгэх ба шаардлагатай тохиолдолд бусад хяналтын чиглэлийн улсын /ахлах/ байцаагчид, төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллага, шинжилгээний ажилтныг татан оролцуулна.

Тав. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа

Шалгалтыг 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Өмнө хийсэн шалгалтын талаарх мэдээлэл

Шинээр баригдаж буй орон сууцны барилгуудад суурилуулж буй ус, дулаан, цахилгааны хэмжих хэрэгслүүдийн хэмжлийн нэгдмэл байдалд өмнө нь хяналт шалгалт хийгдэж байгаагүй.

Долоо. Шалгалтын дүнг танилцуулах

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад танилцуулж, улсын байцаагчийн холбогдох шийдвэрийг хүргүүлнэ.

Засгийн Газрын 2022 оны “Хяналт шалгалт хийх нийтлэг журам батлах тухай” 479 дүгээр тогтоолын 12 дугаар зүйлийн 12.6, 12.7 дахь заалтын дагуу хяналт шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн объект бүрийн мэдээллийг хяналт шалгалтын цахим системд бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.

Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хэмжил зүйн хяналтын улсын байцаагчид урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын танилцуулга болон хавсралт хүснэгтийн дагуу гаргасан судалгааг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний дотор албан бичгээр болон цахим хэлбэр /jargalsaikhan@masm.gov.mn/-ээр Стандарт, хэмжил зүйн газрын Хэмжил зүйн бодлогын газарт ирүүлнэ.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, шалгалтын танилцуулга, улсын байцаагчийн эрх зүйн бусад акт болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж салбарын улсын ерөнхий байцаагчид танилцуулан, гарсан шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны.....дугаар сарын.....ны өдрийн тоот удирдамжийн хавсралт

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН
ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН НЭГДСЭН СУДАЛГАА

№	Аж ахуйн нэгж байгууллагын нэр, регистрийн дугаар	Барилгын хүчин чадал	Хаяг, байршил	Удирдах албан тушаалтны овог нэр, утасны дугаар	Хангач байгууллагаас тоолуурт олгосон техникийн нөхцөлтэй	Техникийн нөхцөлд тоолуурт тавигдах шардлагыг тусгасан	Техникийн нөхцөлд заасан тоолуур, хэмжих хэрэгслийг барилгын зурал төсөлд бүрэн тусгасан	Тоолуур суурилуулсан аж ахуйн нэгж	Тоолуур суурилуулсан аж ахуйн нэгжийн үлнэлээ, бүртгэл	Тоолуурын суурилуулалт стандартын шаардлага хангасан эсэх	Тоолуурын баталгаажуулалт ын гэрчилгээ
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1											
2											
3											

20.... оны сарын өдөр

Судалгаа гаргасан:

.....аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн
Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч...../

/